



МАЛ ЭМНЭЛГИЙН ЭМИЙН
СОРИЛТ, БАТАЛГААЖУУЛАЛТЫН
УЛСЫН ЛАБОРАТОРИ

БАТЛАВ. "МЭЭСБУЛ" УТУГ-ЫН ЗАХИРАЛ:

СТЭСХУЯГ

Тэмдэг

гарын үсэг

9020050559 8292744

ШУДАРГА БАЙДЛЫГ ХАНГАХ ЖУРАМ

БА:УАЖ: 003-2024

Боловсруулсан:

Баталгаажуулалтын албаны шинжээч:

..... *L. Niamsukh* Л.Нямсүх

Хянасан:

Баталгаажуулалтын албаны дарга

..... *S. Oshogorol* С.Өсөхгэрэл

Хэвлэсэн огноо:

2016.09.12

өөрчлөлт № 03

өөрчлөлт оруулсан огноо: 2024.01.02

ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛСАН БҮРТГЭЛ

Д/д	Өөрчлөлт №	Хуудас №	Өөрчлөлт орсон шалтгаан
1.	01	Бүх	Энэхүү журмыг бүхэлд нь дахин хянаж, бие даасан журам болгон оруулав.
2.	01	6-8	Үүрэг амлалтын гэрээний загвар, быаталгааны хуудсын хамт оруулав.
3.	02	Бүх	Байгууллагын статус өөрчлөгдсөнтэй холбоотой өөрчлөлт орсон, дахин хяналт хийсэн
4.	03	Бүх	Бие даасан журам болгон оруулав.

"МЭЭСБУЛ" УТҮГ, Баталгаажуулалтын алба		
Баримт бичгийн № БА:ҮАЖ: 003-2024	Шударга байдлыг хангах журам	
Хэвлэсэн огноо: 2016.09.12	Өөрчлөлт №: 03	Хуудас № 1/7
	Өөрчлөлт орсон огноо 2024.01.02	

АГУУЛГА

Д/д	Бүлэг	Хуудас №
1.	Өөрчлөлт оруулсан бүртгэл	1
2.	Зорилго	2
3.	Хамрах хүрээ	3
4.	“Шударга байдлын хороо”-ны эрх, үүрэг	3
5.	Журам	3
6.	Хариуцлага	4
7.	Холбогдох баримт бичиг	4

“МЭЭСБУЛ” УТҮГ, Баталгаажуулалтын алба		
Баримт бичгийн № БА:ҮАЖ: 003-2024	Шударга байдлыг хангах журам	
Хэвлэсэн огноо: 2016.09.12	Өөрчлөлт №: 03	Хуудас № 2/7
	Өөрчлөлт орсон огноо 2024.01.02	

Нэг. Зорилго

Энэхүү журмын зорилго нь “Малын эм, биобэлдмэл, тэжээлийн нэмэлт бүтээгдэхүүнд баталгаажуулалт хийх схем”-ийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шударга, нээлттэй, хараат бус, ашиг сонирхлоос ангид байх, эрсдэлээс сэргийлэх үүднээс байгуулагдсан “Шударга байдлын хороо”-ны үйл ажиллагааг зохицуулахад оршино.

Хоёр. Хамрах хүрээ

“Шударга байдлын хороо” /цаашид хороо гэх/ болон Баталгаажуулалтын албаны үйл ажиллагаанд оролцогч талуудын үйл ажиллагаанд хамаарна.

Гурав. “Шударга байдлын хороо”-ны эрх, үүрэг

- 3.1. Хорооны гишүүд нь ашиг сонирхлын зөрчлөөс ангид аливаа худалдааны шахалтыг хүлээн зөвшөөрөхгүй байх
- 3.2. Хороо нь баталгаажуулалттай хамааралтай санал, гомдолтой танилцах, хэлэлцэх эрхтэй.
- 3.3. Хорооны ажлын үндсэн хэлбэр нь хуралдаан байх бөгөөд баталгаажуулалтын үр дүнг хэлэлцэн олон нийтэд мэдээлнэ. Хороо нь шаардлагатай тохиолдолд цахимаар хуралдаж болно.
- 3.4. Хороо нь нууцыг хадгалах журмыг баримтлан хэлэлцсэн ажлын үр дүнг олон нийтэд мэдээлнэ.
- 3.5. Хороо нь гаргасан шийдвэрийнхээ хариуцлагыг хүлээнэ.
- 3.6. Хороо нь Баталгаажуулалтын албанаас хараат бусаар үйл ажиллагаа явуулна.
- 3.7. Шударга байдлыг хамгаалах үүднээс Хорооны гишүүд нь Чанарын гарын авлагын 5.2.2 заалтыг мөрдлөг болгон ажиллана.
- 3.8. Хороо нь жилдээ 1-2 удаа хуралдах бөгөөд үр дүнг баталгаажуулалтын алба болон олон нийтэд мэдээлнэ.

Дөрөв. Журам

- 4.1 Шударга байдлын хороо болон гишүүдийг МЭЭСБУЛ-ийн захирлын тушаалаар томилж, чөлөөлнө.
- 4.2 Хорооны гишүүн нь Баталгаажуулалтын үйл явцад оролцдоггүй албан тушаалтан байх, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэгч болон импортлогчийг төлөөлөхгүй байх
- 4.3 Хороо нь дараах заалтуудыг хэрэгжүүлж ажиллана.
 - 4.2.1 Үйл ажиллагааны шударга байдал, ашиг сонирхолоос сэргийлэх, эрсдэлээс хамгаалах бодлого, журмыг хэрэгжүүлсэн байдал,
 - 4.2.2 Баталгаажуулалтын бүхий л үе шатанд схем, дүрэм, журам, тушаал, шийдвэр, үйл ажиллагаа нь үйлчлүүлэгчид шударга, тэгш бус, давуу эрх олгосон эсэх,
 - 4.2.3 Баталгаажуулалтын ажилтны үүрэг амлалтын гэрээ, түүний биелэлтийг хэлэлцэх
 - 4.2.4 Төрийн байгууллага болон үйлчлүүлэгчээс ирсэн санал гомдлыг шийдвэрлэсэн үйл ажиллагааг хэлэлцэх
 - 4.2.5 Баталгаажуулалтын байгууллагын схем, дүрэм, журам, үйл ажиллагааны зөрчил, дутагдлыг арилгуулах саналыг МЭЭСБУЛ-д гаргах
- 4.4 Хорооны хурлын нэг цагийн төлбөрт 15000 төгрөг байхаар тооцож, нэг удаа 2 цаг хуралдан гишүүдэд урамшуулал олгоно.
- 4.5 Хорооны үйл ажиллагаатай холбоотой төлбөр, санхүүгийн асуудлыг “МЭЭСБУЛ” УТҮГ-

“МЭЭСБУЛ” УТҮГ, Баталгаажуулалтын алба		
Баримт бичгийн № БА:ҮАЖ: 003-2024	Шударга байдлыг хангах журам	
Хэвлэсэн огноо: 2016.09.12	Өөрчлөлт №: 03	Хуудас № 3/7
	Өөрчлөлт орсон огноо 2024.01.02	

- ын нягтлан бодогч хариуцна.
- 4.6 Хорооны хурлаар хэлэцүүлэх асуудлыг Баталгаажуулалтын албанаас хурал эхлэхээс 3-5 өдрийн өмнө гишүүдэд цахим эсвэл цаасан хэлбэрээр хүргүүлнэ.
- 4.7 Хорооны хурлын ирц нь 65 %-аас дээш байх бөгөөд нэг гишүүн хүндэтгэн үзэх шалтгаантай тохиолдолд саналыг бичгээр авч хурлыг хийж болно.
- 4.8 Хуралд 2 удаа оролцоогүй гишүүнийг хорооноос чөлөөлнө.
- 4.9 Хурлыг хорооны дарга удирдах бөгөөд шийдвэрийг олонхийн саналаар гаргана. Хуралд танилцуулах тайлан илтгэл 15-30 минут, асуулт хариулт нь 30 минутаас-1цаг, санал нь 15-30 минут байна.
- 4.10 Хурлаас гарсан шийдвэр, үр дүнг Баталгаажуулалтын байгууллагад төлөвлөгөөнд тусгуулан хэрэгжүүлэх саналыг гаргана.

Тав. Хариуцлага

Энэхүү журмыг зөрчсөн албан тушаалтанд холбогдох хууль, журмын дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Зургаа. Холбогдох баримт бичиг

- Шударга байдлыг хангах тухай журам
- Нууцыг хадгалах журам
- Нийтэд нээлттэй байдал
- Үнэлгээ
- Баталгаажуулалтыг олгох, хадгалах, хугацаа сунгах, түр зогсоох, цуцлах журам
- Бүтээгдэхүүнд тохирлын гэрчилгээ олгох
- Гомдол зарга шийдвэрлэх журам

“МЭЭСБУЛ” УТҮГ, Баталгаажуулалтын алба		
Баримт бичгийн № БА:ҮАЖ: 003-2024	Шударга байдлыг хангах журам	
Хэвлэсэн огноо: 2016.09.12	Өөрчлөлт №: 03	Хуудас № 4/7
	Өөрчлөлт орсон огноо 2024.01.02	

ҮҮРЭГ АМЛАЛТЫН ГЭРЭЭ

№ ...

20... оны ... сарын ... өдөр

Улаанбаатар хот

Нэг. Зорилго

Баталгаажуулалтын албаны тохирлын гэрчилгээ олголт, баталгаажуулалтын үйл ажиллагааг шударга нээлттэй явуулахад мэргэжилтнээс тухайн үйлчлүүлэгчтэй хамааралтай эсэхийг тодорхойлоход оршино.

Хоёр. Ерөнхий зүйл

Энэхүү гэрээг нэг талаас “МЭЭСБУЛ” УТҮГ-ын захирал, нөгөө талаас албаны ажилтан овогтой нар “Мал амьтны эрүүл мэндийн тухай” хуулийн 29-р зүйлийн 29.2 дахь заалт, “Эм эмнэлгийн хэрэгслийн тухай” хуулийн 23-р зүйлийн 23.1 дэх заалт, “Стандартчлал техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай” хуулийн 13-р зүйлийн 13.2 дах заалт, MNS ISO IEC 17065:2013, чанарын гарын авлагын 4.2 бүлгийн 3-д заасныг удирдлага болгон байгуулав.

Гурав. Мэргэжилтний баталгаажуулалтын үйл ажиллагаанд шударга ажиллах үүрэг амлалт

3.1 Баталгаажуулалтын үйл ажиллагаанд оролцохдоо MNS ISO IEC 17065:2013 –ийг баримтлан оролцоно.

3.2 Баталгаажуулалтын үйл ажиллагааны явцад олж авсан аж, ахуй нэгж байгууллагын үйлдвэрлэлийн болон технологийн мэдээллийн нууц байдлыг хадгалж, “Нууцыг хадгалах журам”-ыг хэрэгжүүлэн ажиллана.

3.3 Аж, ахуй нэгж байгууллагатай худалдааны болон бусад сонирхлоос хараат бус байх зарчмыг баримтлан ажиллана.

3.4 Хүсэлт гаргагчтай дараах байдлаар харилцаатай буюу ашиг сонирхлын зөрчилтэй бол энэ талаараа удирдлагадаа урьдчилан мэдэгдэж, үнэлгээний ажилд оролцохоос сайн дураараа татгалзана.

“МЭЭСБУЛ” УТҮГ, Баталгаажуулалтын алба		
Баримт бичгийн № БА:ҮАЖ: 003-2024	Шударга байдлыг хангах журам	
Хэвлэсэн огноо: 2016.09.12	Өөрчлөлт №: 03	Хуудас № 5/7
	Өөрчлөлт орсон огноо 2024.01.02	

Үүнд:

- 3.4.1 Бүтээгдэхүүн нийлүүлэгч болон зохион бүтээгч
- 3.4.2 Үйлчилгээ үзүүлэгч буюу боловсруулагч
- 3.4.3 Үйл явцыг ажиллуулагч буюу боловсруулагч

Дөрөв. Гэрээний давтан баталгаажуулалт

Энэхүү гэрээг анх удаа байгуулснаас хойш баталгаажуулалтын үйл явцад оролцох бүрдээ байгуулах ба баталгааны хуудас /хавсралт/-д тухай бүр гарын үсэг зурснаар батлагдсанд тооцно.

Гэрээ байгуулсан

Албан тушаалын нэр: Захирал

Албан тушаалын нэр:

(тамга)

.....
(гарын үсэг) (Эцэг, эхийн нэрийн эхний үсэг, өөрийн нэр)

.....
(гарын үсэг) (Эцэг, эхийн нэрийн эхний үсэг, өөрийн нэр)

20... оны дугаар сарын-ны өдөр

Сунгалт

Албан тушаалын нэр: Захирал

Албан тушаалын нэр:

(тамга)

.....
(гарын үсэг) (Эцэг, эхийн нэрийн эхний үсэг, өөрийн нэр)

.....
(гарын үсэг) (Эцэг, эхийн нэрийн эхний үсэг, өөрийн нэр)

202... оны дугаар сарын-ны өдөр

"МЭЭСБУЛ" УТҮГ, Баталгаажуулалтын алба		
Баримт бичгийн № БА:ҮАЖ: 003-2024	Шударга байдлыг хангах журам	
Хэвлэсэн огноо: 2016.09.12	Өөрчлөлт №: 03	Хуудас № 6/7
	Өөрчлөлт орсон огноо 2024.01.02	

Албан тушаал

Овог нэр

..... тоот гэрээний хавсралт

Үүрэг амлалтын гэрээний баталгаа

Д/д	Хүсэлт гаргагч	Огноо	Гарын үсэг	Тайлбар

“МЭЭСБУЛ” УТҮГ, Баталгаажуулалтын алба		
Баримт бичгийн № БА:ҮАЖ: 003-2024	Шударга байдлыг хангах журам	
Хэвлэсэн огноо: 2016.09.12	Өөрчлөлт №: 03	Хуудас № 7/7
	Өөрчлөлт орсон огноо 2024.01.02	